



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

### Г Оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 60 дугаар зүйлийн 60.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Анд ДД давхар даатгал” ХХК-ийн оноосон нэрийг “Хубилай давхар даатгал” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг “Анд ДД давхар даатгал” ХХК /Я.Дамдинсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН